



Ядуурлын бүх хэлбэрийг бүрэн устгах. Тэгш бус байдал, шударга бус зүйлтэй тэмцэх.

Уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх. Даян дэлхийн эдгээр зорилтууд нь тун чухал бөгөөд дэлхийг өөрчлөхөд улс орнуудын засгийн газрууд, олон улсын байгууллагууд, дэлхийн удирдагчдын хамтын ажиллагаа л шаардлагатай. Харин эгэл жирийн хүн та хийж чадмааргүй зүйл шиг санагдаж байвал тийм биш юм.

Эх дэлхийгээ шинэчлэхэд жирийн иргэн та өөрчлөлтийг өөрөөсөө эхлээрэй. Дэлхийн иргэн бүр - тэр ч байтугай бидний дунд бишгүйдээ байдаг хэнэггүй, залхуу хүмүүс ч - энэ өөрчлөлтийг хөдөлгөгч хүчний нэг хэсэг юм. Бидний өдөр тутмын амьдралдаа тусгаж болох маш энгийн зүйлүүдийг энд санал болгож байгаа бөгөөд эдгээрийг хийснээр ихээхэн өөрчлөлтийг авчирч чадна.

Танд хэрэг болох, таны хийж чадах, улмаар өөрчлөлтийг бий болгох тэр л зүйлүүдийг бид энд нэгтгэн танилцуулж байна. Та үнэхээр чадна.

## Буйдан дээрээ хэвтчихээд хийж болох зүйл

- Цахилгаан хэрэгсэл, компьютер зэргээ ашиглаагүй үедээ бүрэн унтрааж байгаарай. Ингэснээр бид эрчим хүчийг хэмнэж чадна.
- Банкны төлбөр тооцоог электрон болон онлайн хэлбэрээр хийхийг эрмэлзээрэй. Цаасан баримт хэрэглэхгүй байна гэдэг нь ой модыг тайрахгүй гэсэн үг.
- Нийгмийн сүлжээнд уур амьсгалын өөрчлөлт, эмэгтэйчүүдийн эрхийн талаарх сонирхолтой баримт, бичлэгүүдийг илүү олон хүмүүст хүргэхээр хуваалцаж байгаарай.
- Хэвлэхээс татгалз. Та хэвлэх гэж буй зүйлээ онлайнар харах боломжтой эсэхийг бодоорой. Боломжтой зүйлсийг зөөврийн компьютер эсвэл цахим тэмдэглэл дээр бичиж цаас хэмнээрэй.
- Телевиз, компьютерын дэлгэц болон бусад гэрлийг онц шаардлагагүй бол товчлуураар нь дарж бүрэн унтрааж байгаарай.
- Компаниудаас бага ч гэлтгүй зүйлсийг онлайн худалдан авалтаар хийж, байгаль орчинд хохирол учруулахгүй зохистой хэрэглээг сонгоорой.
- Цахим орчинд чатны өрөө, мессеж самбарт дарамт үзүүлдэг кибер гэмт этгээдийг мэдээлж байгаарай.



- Цахим орчин, хэвлэл мэдээллийн хэрэгсэл дээрх @Global-GoalsUN зэрэг хаягнаас Дэлхийн нийтийн 17 зорилтын талаар байнгын мэдээлэл авч байгаарай.
- Нийгмийн сүлжээнд #globalgoals хаштаг ашиглан дэлхий нийтийн 17 зорилтод хүрэхэд өөрийн гаргаж буй санаачлага, үйл ажиллагааныхаа талаар мэдээлээрэй.
- Нүүрстөрөгчийн ялгаруулалтаа нөхөх. Өөрийн гаргаж буй нүүрстөрөгчийн ялгаруулалтаа тооцож уур амьсгалын кредит ClimateNeutralNow-аас худалдан авч сураарай.

## Гэртээ хийж болох зүйл

- Үс, хувцсаа хатаахдаа үсний сэнс, хатаагч машин хэрэглэхээс зайлсхийгээрэй. Угаалгын машинаар хувцсаа угаахдаа хэдхэн хувцас биш, дүүргэж байж угааж заншаарай.
- Богино хугацаанд шүршүүрт орж занших. Ваннтай усанд орох нь 5-10 минут шүршүүрт орохоос ч их ус шаарддаг.
- Махыг үйлдвэрлэхэд ургамлын гаралтай хоол хүнсийг үйлдвэрлэхээс илүү их нөөцийг зарцуулдаг тул амьтны гаралтай мах болон загас хүнсэндээ аль болох бага хэрэглээрэй.
- Бэлтгэсэн хоолоо барахгүй бол шинэхэн дээр нь муудахаас хамгаалж хөргөгчинд хийж байгаарай. Дараа өдөр нь идсэн ч амт нь хэвээрээ байхаас гадна хоол хүнсэндээ зарцуулах мөнгөө хэмнэх болно.



- Хоол хүнсний үлдэгдлээр бордоо хийснээр уур амьсгалын нөлөөллийг бууруулахаас гадна шимт тэжээлт бүтээгдэхүүнийг түргэн хугацаанд боловсруулахад ач холбогдолтой.
- Дахин боловсруулсан цаас, хуванцар, шил, хөнгөн цагаан зэргийг ашигласнаар хог хаягдлыг багасгана.
- Хамгийн бага хэмжээтэй савласан бараа бүтээгдэхүүнийг худалдан авдаг байх.
- Плитка, шарах шүүгээг ашиглахаасаа өмнө халаасны хэрэггүй. Халаах гэж байгаа зүйлдээ л тохируулж, тухайн үед нь залгаж ашигла.
- Цонх болон хаалганы онгорхой хэсгийг бөглөж, дулаалсанаар агаарын болон дулааны эрчим хүчний алдагдлыг бууруулна.
- Хуучин гэрлийн чийдэнгээ эрчим хүчний үр ашигтай LED гэрлээр солих. Мөн гэртээ нарны хавтан байрлуулах сонголт байгаа бол та үүнийг гэртээ авч ашиглах хэрэгтэй. Энэ нь таны цахилгаан эрчим хүчний төлбөрийг багасгана.
- Шалан дээрээ хивс дэвсээрэй. Ингэснээр танай гэрийн дулаан алдагдлыг багасгаж илүү дулаахан байлгана.
- Хэрэв та аяга таваг угаагч машин хэрэглэдэг бол аяга тавгаа эхлээд усаар зайлах хэрэггүй.
- Илүү сайн живх сонгон хэрэглээрэй. Та хүүхэддээ шинэ даавуун живх хэрэглэснээр байгаль орчинд хариуцлагатай хэрэглээг бий болгож чадна.
- Хашааныхаа цасыг өөрөө цэвэрлэснээр таньд дасгал хөдөлгөөн болно. Цас цэвэрлэгч машин нь дуу чимээ ихтэйгээс гадна техникийн гаралтай бохирдлыг байгальд бий болгоно.
- Цаасан хайрцагтай чүдэнзийг сонгоорой. Учир нь хуванцар асаагуурыг байгалийн хий, бензинээр цэнэглэдэг юм.

## Гадаа хийж болох зүйл

- Үндэсний үйлдвэрлэлийг дэмжиж дотоодын бизнес эрхлэгчдийн бүтээгдэхүүнийг худалдан аваарай.
- Ухаалаг худалдан авалт хий. Худалдан авалт хийхээсээ өмнө авах зүйлсийнхээ жагсаалтыг гаргаснаар төлөвлөөгүй худалдан авалт, хүргэлтийн үйлчилгээ гэх мэт маркетингийн аргуудад хууртахгүй байж чадна.
- Хэлбэр, хэмжээ, өнгө зэргээс нь болоод зарим хүнсний ногоог хаяж, хүнсний хаягдал ихээхэн үүсгэдэг. Тэгвэл хэрэглэх ногоогоо аль болох зах дээрээс худалдан авч хэрэглээрэй.
- Зоогийн газарт орж, захиалга өгөхөөсөө өмнө, ялангуяа далайн бүтээгдэхүүний хувьд, тогтвортой мах, загасан түүхий эд хэрэглэдэг эсэхийг мэдэх хэрэгтэй. Ер нь байгальд ээлтэй хоол хүнс худалдан авах жагсаалтаа гаргах нь зөв байдаг.
- Далайн гаралтай хоол хүнс худалдаж авахдаа хариуцлагатай хэрэглээг сонгох. Танд хамгийн аюулгүй хоол хүнсийг аль нь вэ гэдгийг хэлж өгөх олон тооны аппликешн бий.
- Аль болохоор дугуй унаж, явган алхаарай. Эсвэл нийтийн тээврийн хэрэгслээр ч явж болно.
- Дахин хэрэглэж болох усны сав, кофены аяга хэрэглээрэй. Энэ нь хог хаягдлыг багасгахаас гадна таны мөнгийг хэмнэнэ.



- Дэлгүүрт орохдоо даавуун тортой очоорой. Гялгар уут хэрэглэхээс зайлсхийж, олон удаа хэрэглэж болох даавуун тортой бол.
- Цаасан салфетка бага хэрэглээрэй. Идэх бүртээ цаасан салфетка хэрэглэж хаях шаардлагагүй.
- Уламжлалт худалдан авалт хий. Шинэ брэнд тийм ч чухал биш. Танд хэрэгтэй зүйл хуучин хувцасны дэлгүүрт байж мэдэх юм.
- Машинадаа засвар үйлчилгээг тогтмол хийснээр машинаас хорт утаа бага ялгарна.
- Өөртөө хэрэглэхгүй байгаа зүйлээ бусдад өг. Өмсөхгүй байгаа хувцас, ном, тавилгаа ч мөн адил бусдад хандивла.
- Өөрийгөө болон үр хүүхдээ вакцинд хамруулсанаар танай гэр бүлийг өвчнөөс хамгаалаад зогсохгүй нийгмийн эрүүл мэндэд тустай.
- Орон нутаг болон улс орноо удирдагчдыг сонгох сонгуульд оролцож эрхээ эдлээрэй.

## Ажил дээрээ хийж болох зүйл

- Жимс болон хуурай идэх юмыг барахгүй бол хаялгүйгээр хэн нэгэн хэрэгцээтэй хүнд нь өг.
- Танай ажлынхан бүгд эрүүл мэндийг үйлчилгээг авч чаддаг уу? Та ажил дээрээ ямар эрхтэй вэ? Эрх тэгш бус байдлын эсрэг тэмц.
- Залуучуудад үлгэрлэ. Хэн нэгнийг сайхан ирээдүйд хөтөч нь байх боломжтой юм.
- Албан тушаал адил ч эмэгтэйчүүдийн авч буй цалин хөлс эрэгтэйчүүдийнхээс 10-30 хувь бага байна. Адил хөдөлмөрт адилхан цалин олгохын төлөө нэгдэе.
- Дэлхий дээр 4 тэрбум хүн ариун цэврийн наад захын шаардлага хангахгүй орчинд амьдарч байна. Эдгээр олон хүнийг бие засах газартай болгоцгооё.
- Танай ажил дээр эрчим хүчний хэмнэлттэй халаалт болон агааржуулалтын технологийг ашиглаж байна уу? Цаг агаараас хамааран тохируулж байгаарай.
- Мэдээлэлтэй бай. Бусад улс орнуудад бизнес хэрхэн явагдаж байгааг хамтран ажиллагсадтайгаа ярилц.
- Ажлынхаа дэд бүтцийг цэвэр, бат бөх байлгах хөрөнгө оруулалт хийх нь ажилчдыг аюулгүй байдлыг хангах, хүрээлэн буй орчныг хамгаалах цорын ганц арга зам юм.
- Бүх төрлийн ялгаварлан гадуурхалын эсрэг бай. Бүх хүн хүйс, угсаа гарал, нийгмийн байдал болон бие бялдрын хувьд тэгш эрхтэй.



- Ажилдаа явахдаа дугуйгаар, явганаар эсвэл нийтийн тээврийн хэрэгслээр яв. Олуулаа явах бол тус тусдаа машин хэрэглэхээс татгалзаарай.
- Тогтвортой байдлын тухай илүү мэдээллийг [un.org/sustainabledevelopment/be-the-change](http://un.org/sustainabledevelopment/be-the-change) сайтаас авч, ажил дээрээ "байгальд хор хөнөөл, нөлөөгүй" 7 хоног зохион байгуулаарай.
- Санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх. Өөрийн орон нутгийн болон үндэсний эрх баригчдаас хүмүүст болон дэлхийд хохирол учруулахааргүй санаачлага, үйл ажиллагаануудын талаар асууж лавлаарай. Энэ нь Парис хотноо болсон Уур амьсгалын өөрчлөлтийн бага хурлаас гарсан хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулах амлалтанд хүрэхэд дөхөм болно.
- Бидний хуурай газарт бий болгож буй хог хаягдал далай тэнгист шингэж байна.
- Та өдөр тутам гаргаж байгаа шийдвэрээ байгаль орчинд ээлтэй байх, дахин боловсруулах зэрэг шалгуураар хянаж өөрчил. Та хог хаягдлаа дахин боловсруулдаг уу? Танай компани худалдан авалт байгальд ээлтэй юу? гэх мэт,
- Ажил дээр ямар эрхтэйгээ мэдэж ав. Ёс зүйг тогтоохын тулд ямар эрхтэйгээ мэдэх нь чухал.
- Нийгмийн хариуцлагатай бай! Танай байгууллага орон нутгийн иргэдтэй хамтран ажиллаж, тэднийг зорилгодоо хүрэхэд туслаарай.

Эдгээр нь Таны хийж чадах зүйлсийн зөвхөн нэг хэсэг юм шүү. Илүү дэлгэрэнгүй мэдээллийг доорх холбоосоор орж авна уу. <http://www.un.org/sustainabledevelopment/takeaction/>





# ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛ ТӨСӨЛ

## ЗОРИЛГО

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛЫГ МОНГОЛ УЛСЫН ЕБС-ИЙН СИСТЕМД НЭВТРҮҮЛЖ  
ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ БА НОГООН ХӨГЖЛИЙН ТААТАЙ (ИНСТИТУЦИЙН, ЭРХ ЗҮЙН, ЗОХИОН  
БАЙГУУЛАЛТЫН) ОРЧИНГ БҮРДҮҮЛНЭ.

### БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ 1

Тогтвортой хөгжийн боловсролын үзэл санааг ерөнхий боловсролын сургуулиудын сургалтын хөтөлбөрт тусгаж, шинэчлэнэ.

### БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ 2

Олон нийт болон шийдвэр гаргагч нарт тогтвортой хөгжлийн боловсрол, тогтвортой хөгжил, ногоон хөгжлийн тухай мэдээлэл, мэдлэг, үзэл санааг хүргэж, төсөлд хамрагдсан аж ахуйн нэгж, компани, байгууллагуудад байгаль орчны удирдлагын тогтолцоог нэвтрүүлэн ISO 14001 баталгаажуулалт хийлгэнэ.

### ХҮЛЭЭГДЭЖ БҮЙ ҮР ДҮН

Стандарт, сургалтын хөтөлбөр, сурах бичгийг шинэчлэн боловсруулж, эрх бүхий байгууллагаар батлуулж хэвлүүлсэн байна.

Ажиллаж буй болон шинэ багш нарыг сургалтанд хамруулж, тогтвортой хөгжлийн боловсролын агуулга тусгасан сургалт явуулах чадавхи эзэмшсэн байна.

Сургуулийн удирдлага болон үнэлгээний тогтолцоонд ТХБ-ыг нэвтрүүлэхэд сургуулиудыг дэмжинэ.

Тогтвортой хөгжлийн боловсролын сүлжээ байгуулах, үйл ажиллагааг нь идэвхижүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Сургууль, орон нутаг хамтран хэрэгжүүлэх зарим төсөл, арга хэмжээг дэмжинэ.

Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран тогтвортой хөгжлийн боловсрол, тогтвортой хөгжил, ногоон хөгжлийн тухай мэдээллийг олон нийтэд хүргэж, ойлгуулна.

Тогтвортой хөгжил, ногоон хөгжлийн талаарх сургалтыг шийдвэр гаргах түвшний албан тушаалтнууд, хувийн хэвшил болон олон нийтэд зориулан зохион байгуулна.

Тогтвортой хөгжил, ногоон хөгжлийн шинэлэг туршлага бүхий төсөл, төвүүд, эко сургуулиудыг сонгон үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлнэ.

Байгаль орчны удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх зорилгоор зарим компани, байгууллагуудыг сургалтанд хамруулах, ISO 14001 баталгаажуулалт хийлгэхэд дэмжлэг үзүүлнэ.

### ТӨСЛИЙН ТУХАЙ

**ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ХУГАЦАА:** 2015-2018 он (1-р үе шат)

**ТӨСЛИЙН ХАМРАХ ХҮРЭЭ:** Монгол Улс

**САНХҮҮЖҮҮЛЭГЧ:**

Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам  
Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам  
Швейцарийн Хөгжлийн Агентлаг (SDC)

**ЗОРИЛТОТ БҮЛЭГ:** Сурагчид, багш нар, эцэг эхчүүд, олон нийт, их дээд сургуулиуд, төр болон иргэний нийгмийн байгууллагууд, хувийн хэвшил

**ХЭРЭГЖҮҮЛЭГЧ:**

Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (GIZ)  
Упсала Их Сургууль (UU)  
Боловсролын Олон Улсын Хамтын Ажиллагааны Хүрээлэн (IZB)



ТОГТВОРТОЙ  
ХӨГЖЛИЙН

ЗӨРИЛТУУД

1 ҮДҮУРЫГ  
УСТГАХ



2 ҮСГЭДЛИГ  
ЗОГСОВХ



3 ЭРҮҮА МЭНДИЙГ  
ДЭМЖИХ



4 ЧАВАРГАЙ  
БАЛОВСРОЛЫГ  
ДЭМЖИХ



5 ЖЕНДЭРИЙ ЭРХ  
ТЭГШ БАЙДАЛЫГ  
ХАМГААХ



6 БАТАЛГАЙ УДАМЖ  
УС, АРҮҮН СӨРӨН  
БАЙГУУЛАМЖЛАР ХАМГААХ



7 СЭРГЭЭГДЭХ ЭРЧИЙН  
ХҮЧНИЙГ ӨЗӨГРҮҮЛЭХ



8 ЭХИСТӨЙ ХӨДӨЛӨМӨР  
БА ЭДИЙН ЗАСГИЙН  
ӨСӨЛТ



9 ИННОВАЦИ БӨЛӨН ДЭЭ  
БҮЦЭЙГ ХӨГЖҮҮЛЭХ



10 ТЭГШ БУС БАЙДАЛЫГ  
БУУРУУЛАХ



11 ЭЭЛЭЭЙ ХҮТ,  
ИРГЭДИЙН ӨРӨАЦӨГ  
ДЭМЖИХ



12 ХАРЬЦААГАГАЙ  
ХЭРЭГ АЗЭГ ДЭМЖИХ



13 УУР АМЬСГАЛЫН  
ӨРӨАЦАТГИЙН ҮР  
НӨЛӨГ БАГАСГАХ



14 ДАЛАЙ ТЭГИСГИЙН  
НӨВЦНИГ  
ХАМГААЛАХ



15 ХУУРАЙ ГАЗРЫН  
ЭКОСИСТЕМНИЙГ  
ХАМГААЛАХ



16 ЭНХ ТАЙВАН,  
ШУДАРГА ЕСЫГ  
ЦӨГЦӨЛӨХ



17 ХӨГЖЛИЙН ТӨЛӨВХ  
ТҮҮШЭЛЭЛИЙГ  
СЭХЖҮҮЛЭХ



ТОГТВОРТОЙ  
ХӨГЖЛИЙН  
ЗӨРИЛТУУД